



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/1/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас:261740 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Интер аудит ХХК Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхбаяр Цахим хаяг: info@interaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСАД КОВИД-19
ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, БЭЛЭН
БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б.АМАРСАНАА ТАНАА

2024.02.23 № 07/325

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас нийт 27,583,513.1 мянган төгрөгийн 24 ажлын гэрээ байгуулж, 5,389,034.5 мянган төгрөгийн төлбөр хийгдсэн байна. Эдгээр гэрээт ажлуудын 2024 онд хүлээгдэж буй төлбөрийн дүн 22,194,478.6 мянган төгрөг байна.

Аудитын гол асуудал

Төслийн санхүүгийн байдлын тайланд толилуулсан 1,609,225.5 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардал нь 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох нөхцөл бүхий Төслийн санхүүжилтээр хийгдэх Эрүүл мэндийн яам болон НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF)-гийн хооронд байгуулсан “Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээний урьдчилгаа төлбөр байна.

Уг гэрээт ажил нь 2 дэд хэсэг бүхий 2,525.9 мянган ам.долларын төсөвт өртөгтэй ажил бөгөөд I дэд хэсгийн ажлын төлбөр болох 1,955.7 мянган ам.долларын төлбөрийг өмнөх тайлант онуудад тайлант үеийн зардлаар бүртгэсэн байна. II дэд хэсгийн хуваарьт төлбөрийн дүн болох 570.2 мянган ам доллар буюу 1,609,225.5 мянган төгрөгийг 2021 онд шилжүүлж, ажил хүлээлцсэний дараа зардлаар хүлээн зөвшөөрөхөөр хойшлуулсан байна. Хэдийгээр уг гэрээт ажлын хугацаа дуусаж, төлбөрийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээнд заасан цаг хугацаанд гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгч талын зүгээс ирүүлээгүйгээс төслийн зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна. Өмнөх онуудад Дэлхийн банк болон Эрүүл Мэндийн Яамны зүгээс гүйцэтгэгч тал НҮБ-ын Хүүхдийн санд гүйцэтгэлийн тайланг ирүүлэх албан бичгийг удаа хүргүүлсэн боловч одоог хүртэл уг тайланг ирүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийг 2020 оны 04 дүгээр сараас 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр Санхүүжилтийн хэлэлцээрт заасан байна. Тайлант хугацаанд тус төслийг дуусах хугацааг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,572,392,276.59	9,785,630,722.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,962,766,787.14	8,176,159,202.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,962,766,787.14	8,176,159,202.60
31210	Төгрөг	505,297,481.18	5,424,309,346.30
31211	Төрийн сангийн харилцах	505,297,481.18	5,424,309,346.30
31220	Гадаад валют	13,457,469,305.96	2,751,849,856.30
31221	Төрийн сангийн харилцах	13,457,450,807.29	2,751,831,357.63
31223	Арилжааны банк дахь харилцах	18,498.67	18,498.67
33	Авлага	-	246,030.01
33500	Бусад авлага	-	246,030.01
33510	Байгууллагаас авах авлага	-	246,030.01
34	УРЬДЧИЛГАА	1,609,625,489.45	1,609,225,489.45
34600	Урьдчилж гарсан зардал	1,609,625,489.45	1,609,225,489.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	114,277,080.48	83,116,401.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	114,277,080.48	83,116,401.13
392	Биет хөрөнгө	114,277,080.48	83,116,401.13
39203	Авто -тээврийн хэрэгсэл	132,727,272.73	132,727,272.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,363,636.37)	(79,636,363.64)
39205	Машин тоног төхөөрөмж	101,974,567.56	101,974,567.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,913,748.25)	(82,204,995.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,186,156.16	26,186,156.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,333,531.35)	(15,930,236.34)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	6,520,000.00	6,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,520,000.00)	(6,520,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,686,669,357.07	9,868,747,123.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,983,148,606.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,983,148,606.00
413	Өглөг	-	3,983,148,606.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	916,150.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,982,232,456.00
41360	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,686,669,357.07	5,885,598,517.19
51	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	15,686,669,357.07	5,885,598,517.19
512	Хуримтлагдсан үр дүн	15,686,669,357.07	5,885,598,517.19
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,083,369,850.52)	15,686,669,357.07
51220	Тайлант үеийн үр дүн	29,770,039,207.59	(9,801,070,839.88)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,686,669,357.07	9,868,747,123.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	40,762,504,673.85	2,797,746.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,762,504,673.85	2,797,746.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,762,504,673.85	2,797,746.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	40,675,631,111.15	2,797,746.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	40,675,631,111.15	-
120009	Борлуулалтын орлого	(520,983.00)	2,797,746.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	87,394,545.70	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	666,553,823.55	752,692,110.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666,553,823.55	752,692,110.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,553,823.55	752,692,110.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	302,873,257.44	192,170,968.13
210101	Үндсэн цалин	302,873,257.44	192,170,968.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,868,529.52	23,471,242.28
210205	Эрүүл мэндийн даатгал	37,868,529.52	23,471,242.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,424,768.57	89,552,775.49
210304	Байрны түрээс	97,424,768.57	89,552,775.49
2104	Хангамж, бараа материалын зардал	31,937,209.82	9,471,395.27
210401	Бичиг хэрэг	6,071,181.46	336,000.00
210402	Тээвэр шатахуун	6,704,214.64	2,300,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	16,566,356.92	6,589,095.27
210404	Ном, хэвлэл	656,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,939,456.80	246,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,412,861.28	3,536,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	816,181.82	84,800.00
210604	Урсгал засвар	9,596,679.46	3,451,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,788,513.00	7,693,406.00
210702	Дотоод албан томилолт	5,788,513.00	7,693,406.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,067,734.27	393,566,979.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	153,467,734.27	379,740,094.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,600,000.00	1,826,885.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,180,949.65	33,228,743.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,576,220.36	2,068,064.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,604,729.29	31,160,679.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	40,095,950,850.30	(749,894,364.22)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,190,915,617.56	59,285,550.34
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,190,915,617.56	59,285,550.34
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,516,827,260.27	9,110,462,026.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	4,334,474,590.92	-
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	7,182,352,669.35	9,110,462,026.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	29,770,039,207.59	(9,801,070,839.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	9,961,635,829.99	2,797,746.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,961,635,829.99	2,797,746.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,961,635,829.99	2,797,746.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,962,156,812.99	2,797,746.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,962,156,812.99	-
120009	Бусад орлого	(520,983.00)	2,797,746.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	679,509,414.35	720,461,310.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,509,414.35	720,461,310.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,509,414.35	720,461,310.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,491,351.26	184,173,090.41
210101	Үндсэн цалин	325,491,351.26	184,173,090.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,868,529.52	30,799,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,868,529.52	30,799,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,424,768.57	89,552,775.49
210304	Байрны түрээс	97,424,768.57	89,552,775.49
2104	Хангамж, бараа материалын зардал	31,381,085.82	9,071,395.27
210401	Бичиг хэрэг	6,071,181.46	336,000.00
210402	Тээвэр шатахуун	6,148,090.64	1,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,566,356.92	6,589,095.27
210404	Ном, хэвлэл	656,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,939,456.80	246,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,104,588.55	3,536,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,853,727.27	84,800.00
210602	Тавилга	2,654,181.82	-
210604	Урсгал засвар	9,596,679.46	3,451,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,788,513.00	7,693,406.00
210702	Дотоод албан томилолт	5,788,513.00	7,693,406.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	156,874,357.27	393,566,979.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	153,274,357.27	379,740,094.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,600,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,826,885.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,576,220.36	2,068,064.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,576,220.36	2,068,064.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	9,282,126,415.64	(717,663,564.88)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,937.550,497.19	5,128,229,570.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,937.550,497.19	5,128,229,570.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,937.550,497.19	5,128,229,570.00
222001	Тоног төхөөрөмж	5,937.550,497.19	5,128,229,570.00
223001	Бусад хөрөнгө	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(5,937,550,497.19)	(5,128,229,570.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,190,915,617.56	59,285,550.34
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,190,915,617.56	59,285,550.34
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,535,491,536.01	(5,786,607,584.54)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,427,275,251.13	13,962,766,787.14
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,962,766,787.14	8,176,159,202.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	(14,083,900,195.53)	(14,083,900,195.53)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	530,345.01	530,345.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(14,083,369,850.52)	(14,083,369,850.52)
Тайлант үеийн үр дүн	-	-	29,770,039,207.59	29,770,039,207.59
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	15,686,669,357.07	15,686,669,357.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	15,686,669,357.07	15,686,669,357.07
Тайлант үеийн үр дүн	-	-	(9,801,070,839.88)	(9,801,070,839.88)
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	5,885,598,517.19	5,885,598,517.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,867,500,000.00	5,848,690,890.88	18,809,109.12	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	739,000,000.00	720,461,320.88	18,538,679.12	97.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,000,000.00	720,461,320.88	18,538,679.12	97.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	185,500,000.00	184,173,090.41	1,326,909.59	99.3
Үндсэн цалин	185,500,000.00	184,173,090.41	1,326,909.59	99.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,800,000.00	30,799,000.00	1,000.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	30,800,000.00	30,799,000.00	1,000.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,300,000.00	89,552,775.49	3,747,224.51	96.0
Байрны түрээс	93,300,000.00	89,552,775.49	3,747,224.51	96.0
Хангамж, бараа материалын зардал	20,700,000.00	9,071,395.27	11,628,604.73	43.8
Бичиг хэргийн зардал	1,500,000.00	336,000.00	1,164,000.00	22.4
Тээврийн зардал	4,600,000.00	1,900,000.00	2,700,000.00	41.3
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,600,000.00	6,589,095.27	10,904.73	99.8
Ном, хэвлэл	7,600,000.00	-	7,600,000.00	0.0
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	400,000.00	246,300.00	153,700.00	61.6
Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	3,536,600.00	1,463,400.00	70.7
Багаж техник хэрэгсэл	500,000.00	84,800.00	415,200.00	17.0
Тавилга	1,000,000.00	-	1,000,000.00	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	3,451,800.00	(3,451,800.00)	-
Урсгал зардал	3,500,000.00	-	3,500,000.00	0.0
Томилолт, зочны зардал	7,700,000.00	7,693,406.00	6,594.00	99.9
Дотоод албан томилолт	7,700,000.00	7,693,406.00	6,594.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	393,900,000.00	393,566,989.71	333,010.29	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	380,000,000.00	379,740,104.71	259,895.29	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,900,000.00	1,826,885.00	73,115.00	96.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,100,000.00	2,068,064.00	31,936.00	98.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,100,000.00	2,068,064.00	31,936.00	98.5
Хөрөнгийн зардал	5,128,500,000.00	5,128,229,570.00	270,430.00	100.0
Тоног төхөөрөмж	5,128,500,000.00	5,128,229,570.00	270,430.00	100.0

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бусад хөрөнгө	-	-	-	-
Зардлын санхүүжилтийн эх үүсвэр	5,867,500,000.00	-	5,867,500,000.00	0.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,867,500,000.00	-	5,867,500,000.00	0.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,797,746.00	2,797,746.00	-
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	5,867,500,000.00	-	5,867,500,000.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,962,770,655.97	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,176,163,071.43	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	7	6	-	85.7
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	5	-	83.3
Гэрээт ажилтан	0	0	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,982,232.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гэрээний дагуу гүйцэтгэгчийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн төлөгдөөгүй дүнг тайлант оны зардал, бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр төлбөрөөр бүртгэв	1	3,982,232.5	1	3,982,232.5			1	3,982,232.5				
Дүн	1	3,982,232.5	1	3,982,232.5			1	3,982,232.5				

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 120,905.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 3,789.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 117,116.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд ажиллаагүй 2 сарын цалин тооцож олгосон.	1	3,789.1	1	3,789.1								
Зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгоогүй, шууд худалдан авалт хийсэн байна	1	34,000.0			1	34,000.0	-	-				
Үндсэн хөрөнгөд тооллого хийж, баримтжуулаагүй байна.	1	83,116.4			1	83,116.4						
Дүн	3	120,905.5	1	3,789.1	2	117,116.4	-					

Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Орон тооны санхүүгийн мэргэжилтнийг 4 дүгээр сараас хойш тайлант үеийг дуустал томилж ажиллуулаагүй.	1	-			1	
ТХН-ийн жолоочийг томилсон тушаал, шийдвэр гараагүй байхад тухайн албан тушаалтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллуулсан	1	-			1	-
Дүн	2	-			2	-